

МАЛ АНГИЛАХ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

Ангилах зорилго, ач холбогдол. Ангилалт гэдэг нь малыг гаднах шинж тэмдэг, гарал үүсэл, үүлдэрлэг байдал, галбир бие цогцосын бүх үзүүлэлтээр нь үнэлж нэгдсэн үнэлэлт өгч тохирох сүрэгт хуваахыг хэлнэ. Ангилалтын үндсэн дээр цөм сүргийг сонгон илрүүлж, им тэмдэг, дугаар тавьж, удам зүйн нөөцийг зохистой ашиглах ач холбогдолтой.

Мал ангилах гол зорилт нь тухайн үүлдэр, омгийн малын тохиромжтой хэвшлийн шаардлага хангасан хэсгийг сүргийн дотор олшруулж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн чанартай, аль болох их хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлэхэд оршино. Үүний тулд:

а/ тухайн үүлдэр, омгийн малын галбир, бие цогцос, ашиг шимийн босго үзүүлэлтийг бүрэн хангасан цөм сүргийн малыг сонгон илрүүлж, сүрэг сэлбэх өсвөр хээлтүүлэгч бойжуулан нийт сүргийн чанарыг сайжруулах;

б/ урьд хийгдсэн тохируулан сонголтын үр дүнг тооцож, ололт амжилтыг бататгахын зэрэгцээ цаашид сайжруулах шаардлагатай үзүүлэлтүүдийг тогтоож, түүндээ үндэслэн зорилтот тохируулан сонголтыг хэрэгжүүлнэ.

Мал ангилахад хэрэгжүүлэх нийтлэг үйл ажиллагаа: Тухайн төрөл, үүлдэр, омгийн малын ашиг шимийн аль чиглэлд хамрагдаж байгаагаас шалтгаалан ангилалтыг харилцан адилгүй хугацаанд, өөр өөр үзүүлэлтийг үндэслэн аль сүрэгт хамрагдахыг тодорхойлох боловч мал ангилалтын үед дараах нийтлэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- Ангилалтыг итгэмжлэл бүхий дадлага, туршлагатай, мэргэшсэн, ангилагч малзүйч гардаж хийнэ.
- Мал ангилалтыг гүйцэтгэх ажлын хэсгийг эрх бүхий төр, захиргааны байгууллагын шийдвэрээр орон нутгийн мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн, малчдын оролцоотойгоор байгуулж, ангилалт хийх хуваарь, төлөвлөгөөг батална.
- Ангилалт хийхэд шаардагдах хашаа байр, унаа машин, ажиллах хүн хүч, хэрэглэгдэх багаж тоног төхөөрөмж, мал жинлэх пүү, ээмэг, бахь, бүртгэл хөтлөх журнал, маягт зэргийг сум, дүүргийн Засаг дарга бүрэн хангуулсан байна.

- Мал ангилахдаа үндсэн 3 сүрэгт хамруулна:

- 1) Цөм сүрэг
- 2) Үржлийн сүрэг
- 3) Хэрэгцээний сүрэг гэж хуваана.

Цөм сүрэгт хамаарсан малыг ээмэглэж, хувьсын бүртгэлийг холбогдох маягтын дагуу хөтөлнө. Үржлийн болон хэрэгцээний сүрэгт хамрагдсан малыг ангийн им тавьж, цэглэн тэмдэглэнэ.

- Ангилалтад хамрагдсан бог малд дараах байдлаар ангийн им тэмдэг тавина:

- 1) Цөм сүргийн малын баруун чихний үзүүрээс нэг ухам авч зүүн чихэнд ээмэг хийж, хувьсын бүртгэл хөтлөнө.
- 2) Үржлийн сүргийн малын баруун чихний урд талаас нэг ухам авч тухайн ангийн малын бүртгэлд цэглэх аргаар бүртгэнэ.
- 3) Хэрэгцээний сүргийн малын баруун чихний ар талаас нэг ухам авч тухайн ангийн малын бүртгэлд цэглэх аргаар бүртгэнэ.

Ангилалтыг хуваарь, төлөвлөгөөний дагуу хийж дуусгаад нэгдсэн акт бичиж, хичнээн өрх, аж ахуйн нэгжийн нийт хэдэн толгой малыг ангилалтад хамруулж, аль аль сүрэгт хэд хичнээн толгой, ямар нас хүйсний мал хамрагдсаныг баримтанд тулгуурлан бичиж баталгаажуулна.

Тухайн сум, орон нутгийн хэмжээнд шаардлагатай байгаа цөм сүргийн эх малын хангамж, чанар ямар байгаа болон зах зээлийн эрэлт хэрэгцээт бүтээгдэхүүн түүхий эдийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд хээлтүүлэгчийг хэн, хэний цөм сүргээс бойжуулах боломжтой, үржлийн өсвөр хээлтүүлэгч бойжуулах итгэмжлэлийн хугацааг сунгах, эсэх, мөн шинээр итгэмжлэл олгох зэрэг мал сүргийн чанар сайжруулах чиглэлээр хэн юу хийх талаар маш тодорхой зөвлөмж бичиж үлдээнэ.

Мал ангилалтын нэгдсэн дүнгийн товчоог ажлын хэсэг хариуцан дараах маягтын дагуу гаргаж, гарын үсэг зурж, баталгаажуулан ангилалтын актанд хавсаргана.

..... аймгийн сумын
мал сүрэгт ангилалт хийсэн
нэгдсэн дүнгийн товчоо

..... оны сарын..... өдөр.

1	Малчин өрхийн нэр	Ангилалтад хамрагдсан малын		Үүнээс						
		Нас, хүйс	Тоо	Цөм сүрэгт		Үржлийн сүрэгт		Хэрэгцээний сүрэгт		
				Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
1		Нас гүйцсэн хээлтүүлэгч								
		Өсвөр хээлтүүлэгч								
		Нас гүйцсэн хээлтэгч								
		Өсвөр хээлтэгч								
		Бүгд								
n	СУМЫН ДҮН	Нас гүйцсэн хээлтүүлэгч								
		Өсвөр хээлтүүлэгч								
		Нас гүйцсэн хээлтэгч								
		Өсвөр хээлтэгч								
		Бүгд								

Ангилалт хийсэн:

Ажлын хэсгийн ахлагч / /
 Гишүүд..... / /
 / /
 / /
 / /

АДУУ АНГИЛАХ ЗААВАР

Уналга эдэлгээ, спорт, сүү, махны чиглэлээр дараах үүлдэр, омгийн адууг үржүүлж байна:

- 1) Монгол үүлдрийн адуу
- 2) Галшар үүлдрийн адуу
- 3) Тэс омгийн адуу
- 4) Дархад омгийн адуу

Ангилалт явуулах хугацаа: Адууны ангилалтыг жил бүрийн 9–10 дугаар сард явуулж, галбир, бие цогцос, ашиг шимийн үндсэн үзүүлэлтүүдийг харгалзан аль сүрэгт хамрагдахыг тодорхойлно.

Ангилалт хийх зарчим: Үзлэг ангилалтад хамрагдсан адууг дараах сүрэгт хамруулна:

- 4) Цөм сүрэг
- 5) Үржлийн сүрэг
- 6) Хэрэгцээний сүрэг

Өсвөр адууг 3,5-4,5 насанд нь буюу байдсан гүүг хязгаалан, азарган үрээг соёолон насанд анхны ангилалтад хамруулна.

Цөм сүрэгт хамрагдах адуу:

Тухайн үүлдэр, омог, нас, хүйсний цөм сүргийн адууны галбир, бие цогцос, ашиг шимийн босго үзүүлэлтүүдийг хангасан адууг хамруулна.

Үржлийн сүрэгт хамрагдах адуу:

Цөм сүргийн шаардлагыг аль нэг үзүүлэлтээр хангаж чадаагүй үржлийн адууг хамруулна.

Хэрэгцээний сүрэгт хамрагдах адуу:

Үржлийн сүргийн шаардлага хангаагүй адууг оруулна.

Цөм сүргийн адууны босго үзүүлэлтүүд

№	Нас, Хүйс	Мундааны өндөр, см	Цээжний бүслүүр, см	Биеийн ташуу урт, см	Амьдын жин, кг	Онцлог
1. Монгол үүлдрийн адуу						
1	Нас гүйцсэн азарга	130	165	136	360	Адууны гарвал, хэвшил, бие цогцос, галбир хийц, өсөлт хөгжил, тарга хүчний болон үүлдэрлэг байдал, хурдлах чадвар төдийгүй тухайн үүлдрийн ашиг шимийн чиглэлийн онцлогыг харгалзана. Монгол үүлдрийн адуу нь толгой том, шулуун хамартай, намхан мундаатай харьцангуй намхавтар, жижиг биетэй өргөн цээжтэй, нуруу шулуун, шөрмөслөг богино чацтай, хондлой бөөрөнхий, дэл сүүл сахлаг өтгөн, бат бөх цомбон туурайтай, гол төлөв бараан /хээр, хүрэн/ зүстэй адуу байна.
2	Соёолон азарга	128	163	133	340	
3	Нас гүйцсэн гүү	125	160	130	320	
4	Хязаалан байдас	122	150	128	290	
2. Галшар үүлдрийн адуу						
1	Нас гүйцсэн азарга	133	165	139	390	Монгол үүлдрийн адуунд тавигдах нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Галшар үүлдрийн адуу нь толгой хөнгөн, хараа хурц, чих том биш босоо, бие жижгэвтэр нарийхан, арьс нимгэн, дэл сүүл шингэн, ганган галбир хийцтэй, хөлийн шөрмөс тод бүдүүн, туурай нь бат бэх шинжүүд тодорсон, хурдны 3 хэвшилтэй. Хурдны хэвшил нь: Гурван овоо тэгш /сэрвээний өндөр, урд хойд хөл мөчний хэмжээ ижил/ Араатан хэвшил: Толгой хүзүү байц дор, зоо нурууны хэсэгт бөгрөгтөй, хойд мөч урд мөчнөөс өндөр, Зүр хэвшил: Урд мөч нь хойд мөчнөөс өндөр, ууц хондлой бөгрөгтөй Хул хонгор зүстэй байна.
2	Соёолон азарга	130	163	135	350	
3	Нас гүйцсэн гүү	127	160	134	370	
4	Хязаалан байдас	125	154	130	330	
3. Тэс омгийн адуу						
1	Нас гүйцсэн азарга	135	168	138	360	Монгол үүлдрийн адуунд тавигдах нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Тэс омгийн адуу нь биерхэг толгой том ясархаг, хамар монхор, туушингийн хоорондох зай өргөн, аман хүзүү зузаан дөрвөлжин, хонин бор онгирдуу нүдтэй, босоо соотон өд хэлбэрийн чихтэй, чацархаг, хондлой голдуу бөгрөгтөй, хавирга матааслаг, дэл сүүл шингэн, дөрвөн мөч шөрмөс тод, мах булчин хөвчирсэн, илүү нуруу нугаламтай, туурай хавтгай, гахай нь гүн биш шинжүүдээрээ уналга хурдны болон мах уналгын хэшилтэй хээр, хүрэн зүсмийн эрүүл чийрэг адуу байна.
2	Соёолон азарга	130	165	136	350	
3	Нас гүйцсэн гүү	132	163	134	340	
4	Хязаалан байдас	128	160	130	280	
4. Дархад омгийн адуу						
1	Нас гүйцсэн азарга	132	166	138	380	Монгол үүлдрийн адуунд тавигдах нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Дархад омгийн адуу нь богино бахим

2	Соёолон азарга	128	163	137	360	хүзүүтэй, цээж өргөн, гэдэс хэвлий томтой, арьс зузаан, алхаа хөдөлгөөн тайван, уртлаг биетэй, өтгөн дэл сүүлтэй, булчин махны хөгжил сайтай, дөрвөн хөлний ул таваг том, гол ясны хөгжил сайтай, сахлаг үсэн бүрхүүлтэй, урт хар сормуус бүхий бараан зовхи, хөмсөгтэй, цагаан, бор зүсмийн эрүүл чийрэг адуу байна.
3	Нас гүйцсэн гүү	127	161	132	330	
4	Хязаалан байдас	123	158	127	300	

**Адууны хувьсын ангилалт хийхэд хөтлөх
бүртгэлийн маягтын загвар.**

..... аймгийн сумын багийн малчин
ОВОГТОЙЫН үүлдрийн цөм сүргийн адуунд хувьсын
ангилалт хийсэн дэлгэрэнгүй бүртгэл

..... оны сарын ... өдөр

№	Хувьсын дугаар	Адуу			Намрын Амьдын жин	Мундааны өндөр, см	Цээжний бүслүүр, см	Биеийн ташуу урт, см	Үүлдэрлэг байдал	
		Нас	Хүйс	Зүс					Хэвшил	Үүлдэр
1										
2										
3										
4										
.										
.										
.										
.										
n										

Ангилалт хийсэн:

Ажлын хэсгийн ахлагч / /
 Гишүүд..... / /
 / /
 / /
 / /

ТЭМЭЭ АНГИЛАХ ЗААВАР

Ноос, мах, сүү, уналга-эдэлгэний чиглэлээр дараах үүлдрийн тэмээг үржүүлж байна:

- 1) Монгол үүлдрийн тэмээ
- 2) Ханын хэцийн хүрэн үүлдрийн тэмээ
- 3) Галбын говийн улаан үүлдрийн тэмээ
- 4) Төхөм тунгалагийн хүрэн үүлдрийн тэмээ

Ангилалт явуулах хугацаа: Монгол, Ханын хэцийн хүрэн, Галбын говийн улаан, Төхөм тунгалагийн хүрэн үүлдрийн тэмээг 3 дугаар сарын эхний хагаст галбир, бие цогцос, ашиг шимийн үндсэн үзүүлэлтүүдийг харгалзан аль сүрэгт хамрагдахыг тодорхойлно. Цөм сүрэгт хамрагдсан тэмээний ноосны гарцыг хяргалтаар, намрын амьдын жинг 10 дугаар сарын сүүлийн хагаст тус тус тодорхойлж, тухайн тэмээний үржлийн гэрчилгээнд баяжилт хийнэ.

Ангилалт хийх зарчим: Ангилалтад сүрэг сэлбэх насны хээлтэгч (гунжин ингэ), хээлтүүлэгч (бууран тайлаг), өмнө нь ангилалтад хамрагдаагүй үржилд ашиглаж байгаа нас гүйцсэн буур, ингийг хамруулахын зэрэгцээ сум орон нутгийн төр, захиргааны болон мэргэжлийн байгууллагын шийдвэр, өмчийн эзэн, малчдын хүсэлтээр цөм сүргийн бус үржлийн тэмээг давтан үзлэг, ангилалтад хамруулж болно. Ангилалтад хамрагдсан тэмээг галбир, бие бялдар, ашиг шимийн үнэлгээг үндэслэн дараах 3 сүргийн аль нэгэнд хамруулна.

- 1) цөм сүрэг
- 2) үржлийн сүрэг
- 3) хэрэгцээний сүрэг

Цөм сүрэгт хамрагдсан тэмээ:

- Үржлийн ингэ, буур нь лагс чамбай бие цогцостой, мах булчин нягт, ясжилт сайн, толгой хөнгөн, болхи биш, галбирын согоггүй, хөлийн тавилт зөв, үндсэн ашиг шимээр жишиг үзүүлэлтийг хангасан, ноосорхог шинж тэмдэг биеийн хэсгүүдэд жигд илэрч хөгжсөн байна.
- Бууран тайлаг нь зан авир номхон, өвдөг зогдор сахлаг, урт өтгөн эм ноостой, овооны үс намдуу өрөвлөгтэй, бие аялдарын хувьд зузаан, магнай өргөн, нүд бүлтгэр, зөөлөн уужим харцтай, хоёр бөх зайтай тавиу, өргөн цээжтэй, урд хоёр хөл хоорондоо зай ихтэй, бэрэвхийгээр богино

бахим, бүдүүн том гуятай, борвиороо тэнүүн, гэдэс цавьруугаа цүндгэр, нимгэн цомбогор тавагтай, зузаан хар ултай, сагаг босоо, шилбэ богино бүдүүн, хумс хумбагар, төмсөг ил бөгөөд тэгш байрлалтай байна.

- Гунжин тэмээ нь бие тэгш том, цээж өндөр, харц дөлгөөн, гэдэс хэвлий аарцаг хондлой сайтай, ноос сүү арвин, дөлгөөн номхон зантай, тарга хүч сайн авч тогтоодог, дэлэн хөхний хөгжил сайтай байна.
- Цөм сүргийн тэмээнд жил бүр ангилалтын үеэр үзлэг, заазлалтыг тогтмол явуулна.

Үржлийн сүрэгт хамрагдсан тэмээ:

Цөм сүргийн тэмээний галбир, бие цогцос, жин, ноосон ашиг шимийн, гарц, чанарын жишиг үзүүлэлтийн аль нэгийг хангаагүй боловч бусад үзүүлэлтийг хангасан тэмээг хамрагдана.

Хэрэгцээний сүрэгт хамрагдсан тэмээ:

Биеийн өсөлт хөгжилт хангалтгүй, галбирын согогтой, өвчин эмгэгтэй, давжаа жижиг биетэй, эмзэг бие цогцостой үржлийн сүргийн шаардлагыг хангаагүй тэмээг хамруулна.

Цөм сүргийн тэмээний босго үзүүлэлтүүд

№	Нас, хүйсний ялгаа	Амьдын жин. кг		Ноосны гарц, кг	Биеийн хэмжээ . см			Үндсэн зүс, онцлог
		Хаврын	Намрын		Бөх хоорондын өндөр	Биеийн ташуу урт	Цээжний бүслүүр	
1. Монгол үүлдрийн тэмээ								
1	Нас гүйцсэн буур	410	500	8,0	170	148	230	Хүрэн, улаан зүсмийн мах ноосны хосолсон ашиг шимтэй.
2	Ингэ	320	348	5,0	165	145	220	
3	Бууран тайлаг	270	290	4,5	150	130	210	
4	Гунж	230	263	4,0	140	120	205	
2. Ханын хэцийн хүрэн үүлдрийн тэмээ								
1	Нас гүйцсэн буур	570	674	9,0	171,4	150	248	Хар хүрэн, хүрэн зүсмийн ноосорхог шинж илүүтэй тодорсон.
2	Ингэ	480	555	5,5	165	143	230	
3	Бууран тайлаг	450	520	5,0	168	142	225	
4	Гунж	346	420	4,4	163	135	210	
3. Галбын говийн улаан үүлдрийн тэмээ								
1	Нас гүйцсэн буур	656	710	8,0	173	155	230	Улаан, улаан хүрэн зүсмийн махлаг шинж илүү тодорсон.
2	Ингэ	550	620	5,2	168	145	225	
3	Бууран тайлаг	516	570	5,0	170	145	240	
4	Гунж	360	450	4,5	168	140	225	
4. Төхөм тунгалагийн хүрэн үүлдрийн тэмээ								
1	Нас гүйцсэн буур	520	625	11,5	170	150	250	Хүрэн, хүрэн бор зүсмийн ноосон ашиг шим давуутай, хос зогдортой.
2	Ингэ	505	600	7,5	168	140	230	
3	Бууран тайлаг	310	485	6,5	165	135	225	
4	Гунж	300	420	5,0	160	130	220	

Цөм сүргийн тэмээнд хувьсын ангилалт хийхэд хөтлөх бүртгэл

..... аймгийн сумын багийн
 овогтойНЫ тэмээнд явуулсан
 хувьсын ангилалын дэлгэрэнгүй бүртгэл

..... оны сарын ... өдөр.

№	Хувьсын дугаар	Хүйс	Нас	Зүс	Ноосны гарц. кг	Амьдын жин.кг		Биеийн үндсэн хэмжээ.см		
						Хаврын	Намрын	Бөх хоорондын өндөр	Биеийн ташуу урт	Цээжний бүслүүр
1										
2										
3										
.										
.										
.										
.										
.										
.										
n										

Ангилалт хийсэн:

Ажлын хэсгийн ахлагч / /
 Гишүүд / /
 / /
 / /
 / /

ҮХЭР АНГИЛАХ ЗААВАР

Махны чиглэлээр дараах үүлдрийн үхрийг үржүүлж байна.

- 1) Монгол үүлдрийн үхэр
- 2) Дорнод талын махны хэвшлийн үхэр
- 3) Сэлэнгэ үүлдрийн үхэр

Ангилалт явуулах хугацаа: Махны чиглэлийн үржлийн үхэрт ангилалтыг жил бүрийн 10 дугаар сарын сүүлийн хагаст галбир, бие цогцос, махлаг шинжийн үндсэн үзүүлэлтүүдийг харгалзан аль сүрэгт хамрагдахыг тодорхойлно.

Ангилалт хийх зарчим: Ангилалтад хамрагдаж байгаагүй бух, үнээ, нэмрийн гунж, чиглэлтэй бойжуулсан өсвөр бухыг тус тус ангилалтад хамруулна. Үзлэг ангилалтад хамрагдсан үхрийг үүлдэрлэг байдал, ашиг шимийн үзүүлэлтүүдийг харгалзан аль тохирох дараах сүрэгт хамруулна.

- 7) Цөм сүрэг
- 8) Үржлийн сүрэг
- 9) Хэрэгцээний сүрэг

Цөм сүрэгт хамрагдсан үхэр:

Махлаг хэв шинж сайн илэрсэн, өргөн бөөрөнхий биетэй, хонго нь борвио хүртэл булчин махаар дүүрсэн, хүзүү булчин мах сайтай, цээж өргөн, гүн, бөөрөнхий, далны араар ховилгүй бүдэрхий урагш түрж сайтар хөгжсөн, сэрвээ, нуруу, ууц, хондлой өргөн урт махлаг, галбирын согоггүй дэлэн хөх, төмсөгний хөгжил хэвийн, намрын амьдын жингээр тухайн нас, хүйсний тохиромжтой хэвшлийн үхрийн жишиг үзүүлэлтийг хангасан байна. Ангилалтын үеэр цөм сүргийн үхэрт үзлэг, заазлалтыг жил бүр тогтмол хийнэ.

Үржлийн сүрэгт хамрагдсан үхэр:

Цөм сүргийн үхрийн галбир, бие цогцос, амьдын жингийн босго үзүүлэлтийн аль нэгийг хангаагүй боловч бусад үзүүлэлтийг хангасан үхрийг хамруулна.

Хэрэгцээний сүрэгт хамрагдсан үхэр:

Биеийн өсөлт хөгжилт хангалтгүй, галбирын согогтой, өвчин эмгэгтэй, давжаа жижиг биетэй, эмзэг бие цогцостой үржлийн сүргийн шаардлагыг хангаагүй үхрийг хамруулна.

Цөм сүргийн үхрийн босго үзүүлэлтүүд

№	Нас, Хүйс	Амьдын жин, кг /намар/	Биеийн хэмжээ, см			Үндсэн зүс, онцлог
			Биеийн ташуу урт	Цээжний бүслүүр	Сэрвээни й өндөр	
1. Монгол үүлдрийн үхэр						
1	Бух	360	140	175	118	Үхрийн хэвшил, бие цогцос, галбир хийц, өсөлт хөгжил, тарга хүчний болон үүлдэрлэг байдал, ашиг шимийн чиглэлийн онцлогыг харгалзана. Монгол үүлдрийн үхэр нь махлаг хэв шинжийг сайн илэрхийлсэн өргөн бөөрөнхий биетэй, булчин ясны хөгжил сайтай толгой үүлдрийнхээ шинжийг хадгалсан, хүзүү булчин мах сайтай, ихэвчлэн хумбан босоо эвэртэй, дагзны товгоргүй харьцангуй өргөн цээжтэй, жижиг биетэй, нуруу шулуун, шөрмөслөг богино чацтай, гол төлөв улаан, хүрэн зүсмийн эрүүл чийрэг үхэр байна.
2	Үнээ	310	130	170	116	
3	Өсвөр бух	340	125	160	110	
4	Нэмрийн гунж	240	120	155	107	
2. Сэлэнгэ үүлдрийн үхэр						
1	Бух	420	155	183	125	Махны хэвшлийг бүрэн хадгалсан, гуя хонгоны махны дүүргэлт сайн, булчин махны хөгжил жигд, цээж бөгс тэнцүү, нядлагын гарц, жингээр махны төрөлжсөн үүлдэртэй ойролцоо Гүн улаан халзан зүстэй, нүдний цагираг улаан хүрээтэй, бэлхүүс, сэрвээ, сүүлний үзүүр цагаан.
2	Үнээ	380	150	178	117	
3	Өсвөр бух	320	130	170	115	
4	Нэмрийн гунж	280	130	165	112	
3. Дорнод талын махны хэвшлийн үхэр						
1	Бух	400	142	177	122	Үхэрт тавигдах нийтлэг шаардлага нь Монгол үүлдрийн үхрийхтэй адилхан. Дорнод талын махны хэвшлийн үхэр нь махлаг хэв шинжийг сайн илэрхийлсэн өргөн бөөрөнхий биетэй, булчин ясны хөгжил сайтай хэвшлийнхээ хэв шинжийг хадгалсан удамуудтай. Эдгээр удамын онцлогийг харгалзан аль сүрэгт хамаарахыг тогтооно. Тамир удам: Мухар улаан, хар зүстэй, Бэрлэг удам: Хумбан эвэртэй, бидэртэй хүрэн зүстэй хамрын толионы эргэн тойронд цайвар.
2	Үнээ	360	134	172	118	
3	Өсвөр бух	380	130	170	115	
4	Нэмрийн гунж	270	127	165	113	

САРЛАГ АНГИЛАХ ЗААВАР

Мах-сүү-хөөвөрний чиглэлээр үржүүлж байгаа Монгол үүлдрийн сарлагийн удам зүйн нөөцийг хамгаалан сайжруулах зорилгоор ангилалт явуулна.

Ангилалт явуулах хугацаа: Сарлаг ангилалтыг жил бүрийн 5, 10 дугаар сард галбир, бие цогцос, ашиг шимийн үндсэн үзүүлэлтүүдийг харгалзан аль сүрэгт хамрагдахыг тодорхойлно.

Ангилалт хийх зарчим: Ангилалтад хамрагдаж байгаагүй бух, үнээ, нэмрийн гунж, чиглэлтэй бойжуулсан өсвөр бухыг тус тус ангилалтад хамруулна. Үзлэг ангилалтад хамрагдсан сарлагийг гарвал, ашиг шимийн үзүүлэлтүүдийг харгалзан аль тохирох дараах сүрэгт хамруулна:

- 1) Цөм сүрэг
- 2) Үржлийн сүрэг
- 3) Хэрэгцээний сүрэг

Цөм сүрэгт хамрагдсан сарлаг:

Махлаг хэв шинж сайн илэрсэн, өргөн бөөрөнхий лагс биетэй, биеийн хэсгүүдийн харьцаа тохирсон, бахим чийрэг, толгой том биш, хүзүү махлаг зузаан богиновтор, сэрвээ өндөр, их биеийн дунд хэсэг уужим, тавиу, ууц нуруу, хондлой махлаг, өргөн, тэгш урт, гуя хонго махлаг өргөн зузаан, хөл мөч бахим богиновтор шулуун, туурай бөх бат, савга сүүл өтгөн, эх биеийн үсэн бүрхүүл сахлаг, ноолуур ихтэй эрүүл чийрэг сарлаг байна.

Үржлийн сүрэгт хамрагдсан сарлаг:

Цөм сүргийн сарлагийн галбир, бие цогцос, амьдын жингийн босго үзүүлэлтийн аль нэгийг хангаагүй боловч бусад үзүүлэлтийг хангасан малыг хамруулна.

Хэрэгцээний сүрэгт хамрагдсан сарлаг:

Биеийн өсөлт хөгжилт хангалтгүй, галбирын согогтой, өвчин эмгэгтэй, давжаа жижиг биетэй, эмзэг бие цогцостой үржлийн сүргийн шаардлагыг хангаагүй сарлагийг хамруулна.

Цөм сүргийн сарлагийн босго үзүүлэлтүүд

№	Нас, Хүйс	Амьдын жин, кг /намар/	Сүүний гарц Литр /100 хоногийн дундаж саам/	Ноосны гарц. кг		Биеийн хэмжээ. см		
				Хөөвөр	Хялгас	Биеийн ташуу урт	Цээжний бүслүүр	Сэрвээний өндөр
1	Бух	400		0,7	1,0	152,0	204,0	128,0
2	Үнээ	290	270	0,4	0,6	120,0	168,0	108,0
3	Өсвөр бух	250		0,5	0,7	106,0	143,0	90,0
4	Нэмрийн гунж	225	200	0,5	0,6	84,0	118,0	75,0

**Махны чиглэлийн цөм сүргийн үхэрт хувьсын
ангилалт хийхэд хөтлөх бүртгэл**

..... аймгийн сумын багийн
овогтойны үүлдрийн /хэвшлийн/ үхэрт явуулсан
хувьсын ангилалын дэлгэрэнгүй бүртгэл

..... оны сарын ... өдөр.

№	Хувьсын дугаар	Хүйс	Нас	Зүс	Хаврын амьдын жин.кг	Биеийн үндсэн хэмжээ.см			Үүлдэрлэг байдал	
						Сэрвээний өндөр	Биеийн ташуу урт	Цээжний бүслүүр	Удам, хэвшил	Үүлдэр
1										
2										
3										
.										
.										
.										
.										
.										
.										
n										

Ангилалт хийсэн:

Ажлын хэсгийн ахлагч / /

Гишүүд / /

..... / /

..... / /

..... / /

Цөм сүргийн сарлагт хувьсын ангилалт хийхэд хөтлөх бүртгэл

..... аймгийн сумын багийн
 овогтойНЫ сарлагт явуулсан хувьсын
 ангилалын дэлгэрэнгүй бүртгэл

..... оны сарын ... өдөр.

№	Хувьсын дугаар	Хүйс	Нас	Зүс	Ноосны гарц. кг		Амьдын жин.кг		Биеийн үндсэн хэмжээ.см		
					Хөөвөр	Хялгас	Хаврын	Намрын	Сэрвээний өндөр	Биеийн ташуу урт	Цээжний бүслүүр
1											
2											
3											
.											
.											
.											
.											
.											
.											
n											

Ангилалт хийсэн:

Ажлын хэсгийн ахлагч /
 Гишүүд /
 /
 /
 /

ХОНЬ АНГИЛАХ ЗААВАР

Ангилалтын зорилго, ач холбогдол.

Хонин сүргийн ашиг шимийн гарц, чанарыг зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн сайжруулж, биологийн нөөц боломжийг бүрэн дүүрэн илрүүлэн зохистой ашиглаж, эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар хонь үржүүлэгчдийн ашиг орлогыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой, мэргэжлийн өндөр түвшинд хийх шаардлагатай чухал ажил үйлчилгээ юм.

“Шилж өсгөн – ширвэж хэрэгцээлэх” ардын селекцийн уламжлалт үйл ажиллагааг, шинжлэх ухааны үндэслэлтэй үржил селекцийн ажилтай хослон хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх цорын ганц багаж, хэрэгсэл болсон стандартын шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгчийг бойжуулах зориулалт бүхий цөм сүргийн эх малыг ангилалт, шилэн сонголтоор зөв илрүүлж, зохистой ашиглах замаар нийт сүргийн ашиг шимийн гарц, чанарыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ болно.

Ашиг шимийн чиглэлийг харгалзан ангилалт явуулах: Монгол үүлдрийн хонины үүлдэрлэг байдлыг сайжруулан, ашиг шимийг нэмэгдүүлэх төр, засгийн бодлогын хүрээнд хонин сүргийг өөр дотор нь сонгон үржүүлэхийн зэрэгцээ гадаадын арвин ашиг шимт үүлдрүүдтэй эрлийзжүүлэх үйлдвэрлэл - эрдэм шинжилгээ – үржил селекцийн ажлыг өргөн хүрээнд тууштай явуулсны үр дүнд ашиг шимийн шинэ чиглэл бүхий удамзүйн нөөцийн материалаар баяжуулж ирсэн билээ.

Монгол оронд үржүүлж байгаа хонин сүрэгт дараах ашиг шимийн чиглэлийн дагуу ангилалтыг явуулна:

1. Мах – өөх - бүдүүн ноосны чиглэлийн өөхөн сүүлт хонь
2. Мах – өөх- бүдүүвтэр ноосны чиглэлийн өөхөн сүүлт хонь
3. Мах – өөх – бүдүүн, бүдүүвтэр ноосны чиглэлийн ууцан сүүлт хонь
4. Мах - өөх - нарийн, нарийвтар ноосны чиглэлийн хонь
5. Мах – өөх - хурганы арьсны чиглэлийн бүдүүн ноост өөхөн сүүлт хонь

Ангилалт хийх зарчим: Ашиг шимийн тухайн чиглэлийн хонийг зүс, галбир, шүд, хөл мөчний болон үржлийн эрхтэн, дэлэн хөхний хэлбэр хэмжээ, биеийн ерөнхий өсөлт хөгжилтийн зэрэгцээ махлаг шинжүүдийн гадаад илэрхийлэл болох

ууц нуруу, сүүл сүвээний харьцаа, эрүүл мэнд, тэсвэрт чанар, ноос, хурганы арьсан ашиг шимийн үндсэн үзүүлэлтүүдийг харгалзан аль сүрэгт хамрагдахыг шийдвэрлэх зарчим баримтлана.

Ангилалтад хамрагдах хонины нас, хүйс: Ангилалтад сүрэг сэлбэх насны хээлтэгч (охин төлөг), хээлтүүлэгч (хуцан төлөг), үржилд ашиглаж байгаа нас гүйцсэн хуц, өмнө нь ангилалтанд хамрагдаагүй бүх эм хонь, цөм сүргийн эм хонийг хамруулахын зэрэгцээ сум орон нутгийн төр, захиргааны болон мэргэжлийн байгууллагын шийдвэр, өмчийн эзэн, малчдын хүсэлтээр цөм сүргийн бус эм хонийг давтан үзлэг, ангилалтад хамруулж болно.

Нэг. “Мах – өөх - бүдүүн ноос”-ны чиглэлийн өөхөн сүүлт хонь ангилах заавар

Монголчууд эрт дээр үеэс бүдүүн ноост монгол хонийг дагнан өсгөн үржүүлж, мах, ноос, арьс нэхий, сүү зэрэг олон төрлийн ашиг шимийг ахуй амьдралдаа өдөр тутамд өргөн ашигласаар ирсэн түүхтэй. Хонь хэдийгээр байгаль, цаг уурын эрс тэс байдал, бэлчээрийн маллагааны нөхцөлд дасан зохицсон, тэсвэр хатуужил сайтай ч ашиг шим, таваарлаг чанараар зах зээлийн өнөөгийн эрэлт хэрэгцээг төдийлөн сайн хангахгүй байгаа тул ашиг шимийн олон чиглэлээр өсгөн үржүүлэх шаардлага улам бүр өсөн нэмэгдэж байна. Тэдгээрийн нэг болох “Мах-өөх-бүдүүн ноос”-ны чиглэлээр дараах үүлдэр, үржлийн хэсэг, омгийн хонийг хамруулан үржүүлж байна:

- 1) Монгол үүлдрийн хонь
- 2) Үзэмчин үүлдрийн хонь
- 3) Барга үүлдрийн хонь
- 4) Баяд үүлдрийн хонь
- 5) Хотонт үржлийн хэсгийн хонь
- 6) Баянгол омгийн хонь
- 7) Буриад омгийн хонь

Ангилалт явуулах хугацаа: Ашиг шимийн энэ чиглэлд хамаарах дээрх үүлдэр, үржлийн хэсэг, омгийн хонийг үржүүлж байгаа иргэд, аж ахуйн нэгжийн хонинд ангилалтыг жил бүрийн 10 дугаар сарын эхний хагаст багтаан, мах-өөхний хэв шинж тодорсон байдал болон галбир, биеийн ерөнхий өсөлт, хөгжилтийн үзүүлэлтүүдийг голлон шинжиж ангилна. Жил бүр цөм сүрэгт хамрагдсан хонинд хяналтын хяргалт, 5 дугаар сард хаврын амьдын жинг тодорхойлж үржлийн гэрчилгээнд баяжилт хийнэ.

Ангилалт явуулах зарчим: Хонины ашиг шимийн болон галбир, бие бялдар, үржлийн чанарт үнэлгээ өгснөөр ямар сүрэгт хамрагдахыг тодорхойлох бөгөөд үржлийн болон хэрэгцээний сүрэгт орох хонинд ангийн ангилалт хийж, им тавьж, бүртгэлд хамруулна. Харин цөм сүргийн шаардлага хангасан хонинд хувьсын ангилалт хийж, хонь нэг бүрийн босго үзүүлэлтүүдийг хувьсийн бүртгэлд маягтын дагуу хөтлөнө.

Цөм сүрэгт хамрагдах хонь:

- Биеийн ерөнхий хэсгүүдийн харьцаа зөв, эрүүл чийрэг байхын зэрэгцээ тухайн үүлдэр, омгийн уг нас, хүйсний хонины намрын амьдын жингийн босго үзүүлэлтээс дээш амьдын жинтэй, чийрэг бие цогцостой байна.
- Тухайн үүлдэр, үржлийн хэсэг, омгийн хонины үндсэн зүстэй;
- Шүдний тоо тухайн хониныхоо насанд тохирсон бүрэн, бүтэн, зөв ургалттай;
- Толгойн урт өргөний харьцаа зөв, дээд доод уруулын хөгжил ижил, эвэртэй бол хар бараан өнгийн, хэвийн хэлбэр, хэмжээтэй;
- Сэрвээ нуруу тэгш шулуун, махлаг өргөн, хондлой урт, өргөн, хоёр талын түнхний үе нэг түвшинд байрлалтай, гуя хонгоны хэсэг махлаг;
- Сүүлний үзүүр нь боривоо хүрээгүй эргэсэн богинохон, сүүлний уг нь ууц нурууны чиг шугамтай нэг түвшинд байрласан, шувтан унжуу биш, дугуй, мухар, махир хэлбэрийн, урт өргөн ойролцоо хэмжээтэй, зузаан өөхөн сүүлтэй;
- Хөл шулуун, үе мөч, хөлийн гишгэлт хэвийн зөв, хэвийн хөгжил бүхий хар бараан өнгийн туруутай;
- Хээлтүүлэгч малын хоёр төмсөг нь лийр хэлбэртэй, адил тэнцүүхэн хөгжилтэй, хуухнагын нэг уутанцарт зөв байрласан;
- Хээлтэгч малын дэлэн нь аяга хэлбэртэй, суурь нь өргөсөж хэвлийд сайтар бэхлэгдсэн, хоёр хөхний хэлбэр, хэмжээ тэнцүүхэн зөв байрлалтай;

Үржлийн сүрэгт хамрагдах хонь:

- Цөм сүргийн хонины шаардлага, босго үзүүлэлтийг аль нэг үзүүлэлтээр хангаагүй боловч үржилд ашиглан үр төлийг авах боломжтой;
- Тухайн үүлдэр, үржлийн хэсэг, омгийн хонины үндсэн зүсний эзлэх хэмжээ уг хонины нийт биеийн **75%** -иас доошгүй;

Хэрэгцээний сүрэгт хамрагдах хонь:

- Өсөлт хөгжилт, махлаг шинж муутай, галбирын согогтой, тухайн нас, хүйсний цөм сүргийн хонины амьдын жингийн босго үзүүлэлтээс **20%**-иар доогуур, жижиг давжаа биетэй;

**“Мах – өөх - бүдүүн ноос”-ны чиглэлийн өөхөн сүүлт
хонины цөм сүргийн босго үзүүлэлтүүд**

1	Нас, хүйсний ялгаа	Амьдын жин. кг		Ноосны гарц. кг	Товч тайлбар
		Хаврын	Намрын		
1. Монгол үүлдрийн хонь					
1	Нас гүйцсэн хуц	45.0	60.0	1.4	Халзан, хар толгойтой, цагаанаас өөр зүсний хэмжээ их биеийн 10% -иас хэтрээгүй, хар бараан өнгийн эвэр, туруутай, нуруу тэгш, шулуун, махлаг өргөн, хондлой урт, өргөн, гуя хонгоны хэсэг махлаг, дугуй, мухар, махир хэлбэрийн, урт өргөн ойролцоо хэмжээтэй, зузаан өөхөн сүүлтэй, хөл шулуун, үе мөч, хөлийн гишгэлт хэвийн зөв хөгжсөн, хоёр төмсөг нь лийр хэлбэртэй, адил тэнцүүхэн хөгжилтэй, хуухнагын нэг уутанцарт зөв байрласан, дэлэн нь аяга хэлбэртэй, суурь нь өргөсөж хэвлийд сайтар бэхлэгдсэн, хоёр хөхний хэлбэр, хэмжээ тэнцүүхэн зөв байрлалтай, эрүүл чийрэг, галбирын согоггүй хонь байна.
2	Төлгөн хуц	32.0	45.0	1.1	
3	Эм хонь	35.0	48.0	1.2	
4	Охин төлөг	28.0	36.0	1.0	
2. Үзэмчин үүлдрийн хонь					
1	Нас гүйцсэн хуц	52.0	65.0	1.2	Монгол үүлдрийн хонины товч тайлбар дахь нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Үзэмчин үүлдрийн хонь нь шар халзан, шар, улаан толгойтой цагаан зүстэй, мах-өөхний хэв шинж илүүтэй тодорсон, богино тачир ямаан үс бүхий бүдүүн ноостой, сүүл нь дугуй буюу өргөн том, эрүүл чийрэг, галбирын согоггүй хонь байна.
2	Төлгөн хуц	33.0	50.0	1.0	
3	Эм хонь	40.0	55.0	1.1	
4	Охин төлөг	30.0	45.0	0.8	
3. Барга үүлдрийн хонь					
1	Нас гүйцсэн хуц	50.0	63.0	1.2	Монгол үүлдрийн хонины товч тайлбар дахь нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Барга үүлдрийн хонь нь мах-өөхний хэв шинж сайн тодорсон, улаан толгойтой, шар халзан зүстэй, сүүл ууц нуруундаа харьцангуй их хэмжээний өөх хуримтлуулсан, бага зэрэг өргөгдсөн богино зузаан отгогүй мухар өөхөн сүүлтэй, галбирын согоггүй, эрүүл чийрэг хонь байна.
2	Төлгөн хуц	32.0	46.0	1.0	
3	Эм хонь	39.0	52.0	1.1	
4	Охин төлөг	30.0	42.0	0.9	
4. Баяд үүлдрийн хонь					
1	Нас гүйцсэн хуц	43.0	65.0	2.0	Монгол үүлдрийн хонины товч тайлбар дахь нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Баяд үүлдрийн хонь нь халзан, хар толгойтой, их бие цагаан, богинохон дөрвөлжин биетэй, мах-өөхөн ашиг шимийн хэв шинж тод илэрсэн, ууцандаа өргөгдсөн богино дугариг хэлбэрийн отгогүй, мухар огтор өөхөн сүүлтэй, хар бараан туруутай, туг хэлбэрийн бүдүүн ноостой, эрүүл чийрэг хонь байна.
2	Төлгөн хуц	33.0	47.0	1.7	
3	Эм хонь	38.0	54.0	1.6	
4	Охин төлөг	31.0	40.0	1.4	
5. Хотонт үржлийн хэсгийн хонь					
1	Нас гүйцсэн хуц	45.0	60.0	1.5	Монгол үүлдрийн хонины товч тайлбар дахь нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Хотонт үржлийн хэсгийн хонь нь мах-өөхний хэвшил илүү тодорсон, сээр нурууны 1-2 нугалам илүү, сүүл нь дугуй, өргөн том, халзан, хар нүдэн, хар толгойтой цагаан зүстэй, туг хэлбэрийн бүдүүн ноостой, эрүүл чийрэг хонь байна.
2	Төлгөн хуц	32.0	47.0	1.3	
3	Эм хонь	38.0	50.0	1.2	
4	Охин төлөг	28.0	42.0	1.1	
6. Баянгол омгийн хонь					

1	Нас гүйцсэн хуц	54.0	65.0	1.6	Монгол үүлдрийн хонины товч тайлбар дахь нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Баянгол омгийн хонь нь махны хэв шинж илүүтэй хөгжсөн, дал хондлой өргөн, бөөрөнхий, хавирганы матаас сайтай, дугариг хэлбэрийн том өөхөн сүүлтэй, хар, шар нүдэн, халзан, их бие цагаан зүстэй, туг хэлбэрийн бүдүүн ноостой, эрүүл чийрэг хонь байна.
2	Төлгөн хуц	37.0	45.0	1.4	
3	Эм хонь	38.0	52.0	1.3	
4	Охин төлөг	31.0	42.0	1.1	

7. Буриад омгийн хонь

1	Нас гүйцсэн хуц	60.0	70.0	1.8	Монгол үүлдрийн хонины товч тайлбар дахь нийтлэг босго үзүүлэлтүүдтэй ижил байхын зэрэгцээ Буриад омгийн хонь нь цээж өргөн, гүн, ууц ялимгүй өргөгдсөн, харьцангуй богино зузаан өөхөн сүүлтэй, улаан, шар, бор толгойтой, их бие нь хундан цагаан зүстэй, туг хэлбэрийн бүдүүн ноостой, эрүүл чийрэг хонь байна.
2	Төлгөн хуц	35.0	52.0	1.2	
3	Эм хонь	40.0	55.0	1.3	
4	Охин төлөг	32.0	48.0	1.1	

Хавсралт № 2

Мах-өөх-бүдүүн ноосны чиглэлийн цөм сүргийн хонинд хувьсын ангилалт хийхэд хөтлөх бүртгэлийн маягтын загвар.

..... аймгийн сумын багийн малчин
..... овогтой-ын үүлдрийн цөм сүргийн
хонинд хувьсын ангилалт хийсэн дэлгэрэнгүй бүртгэл

..... оны сарын ... өдөр.

№	Хувьсын дугаар	Хонины			Намрын амьдын жин кг	Тайлбар
		Хүйс	Нас	Зүс		
1						
2						
3						
.						
.						
.						
.						
n						

Ангилалт хийсэн:

Ажлын хэсгийн ахлагч /
 Гишүүд..... /
 /
 /
 /

Хоёр. “Мах – өөх - бүдүүвтэр ноос”-ны чиглэлийн өөхөн сүүлт хонь ангилах заавар.

“Мах-өөх-бүдүүвтэр ноос”-ны чиглэлээр дараах үүлдэр, үүлдрийн хэсэг, омгийн хонийг хамруулан үржүүлж байна:

- 1) Байдраг үүлдрийн хонь
- 2) Говь-Алтай үүлдрийн хонь
- 3) Сартуул үүлдрийн хонь
- 4) Дархад үүлдрийн хонь
- 5) Тамир үүлдрийн хэсгийн хонь
- 6) Сутай омгийн хонь

Ангилалт явуулах хугацаа: Ашиг шимийн энэ чиглэлд хамрагдах дээрх үүлдэр, үүлдрийн хэсэг, омгийн хонийг үржүүлж байгаа иргэд, аж ахуйн нэгжийн хонинд ангилалтыг жил бүрийн 5 дугаар сарын эхний хагаст мах-өөхний болон галбир, ноосон ашиг шимийн үндсэн босго үзүүлэлтүүдийг үндэслэн шинжиж ангилна.

Жил бүр цөм сүрэгт хамрагдсан хонинд хяналтын хяргалт, 10 дугаар сард амьдын жинг тодорхойлж үржлийн гэрчилгээнд баяжилт хийнэ.

Ангилалт хийх зарчим: Ашиг шимийн энэ чиглэлийн хонины үндсэн үзүүлэлтүүд нь “Мах – өөх - бүдүүн ноос”-ны чиглэлийн өөхөн сүүлт хонь ангилах заавартай ижил бөгөөд ноосорхог шинжүүдийн гадаад илэрхийлэл болох ноосон дахь үсний төрлийн харьцаа, ноолуур, сор үсний урт, голч, ноолуурын эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан аль сүрэгт хамрагдахыг тодорхойлох зарчим баримтална.

Цөм сүрэгт хамрагдах хонь:

- Хонины гэдэс хээлүүрийн ноосжилт сайтай, урд, хойд хөлний ноосжилт өвдөг, борвио хүртэл үргэлжилсэн, ямаан үсгүй, туг хэлбэрийн бүдүүвтэр ноостой;
- Ноосны чанар /Ноолуур, сор үсний урт, голч, ноолуурын эзлэх хувь/ нь хавсралтад заасан тухайн нас, хүйсний хонины босго үзүүлэлтүүдийг хангасан байх;
- Тухайн үүлдэр, үүлдрийн хэсэг, омгийн хонины үндсэн зүстэй байх;

Үржлийн сүрэгт хамрагдах хонь:

- Цөм сүргийн хонины шаардлага, босго үзүүлэлтийг аль нэг үзүүлэлтээр хангаагүй боловч үржилд ашиглан үр төлийг авах боломжтой;
- Тухайн үүлдэр, үүлдрийн хэсэг, омгийн хонины үндсэн зүсний эзлэх хэмжээ уг хонины нийт биеийн **80%** -иас доошгүй;

Хэрэгцээний сүрэгт хамрагдах хонь:

- Өсөлт хөгжилт, махлаг болон ноосорхог шинж муутай, галбирын согогтой, өвчин эмгэгтэй, тухайн нас, хүйсний цөм сүргийн хонины амьдын жингийн босго үзүүлэлтээс 20%-иар доогуур, жижиг давжаа биетэй, ноосон дахь ноолуурын эзлэх хувийн жин 60%-иас доош үзүүлэлттэй;

**“Мах – өөх - бүдүүвтэр ноос”-ны чиглэлийн өөхөн сүүлт
хонины цөм сүргийн босго үзүүлэлтүүд**

№	Нас, хүйсний ялгаа	Амьдын жин. кг		Ноосны					Товч тайлбар
		Хаврын	Намрын	Гарц кг	Урт. см		Ноолуурын эзлэх хувь	Чанар	
					Ноолуур	Сор			
1. Байдраг үүлдрийн хонь									
1	Нас гүйцсэн хуц	48.0	60.0	2.0	10	15	83	46-48	Ноосны хэв шинж илүү тодорсон, чийрэг бие цогцостой, галбирын согоггүй, халзан, хар нүдэн, хар толгойтой, цагаанаас өөр зүс биеийн 10% -иас хэтрээгүй, хар эвэр, туурайтай, торгомсог, урт бүдүүвтэр ноостой, өөхөн сүүлтэй, эрүүл чийрэг хонь байна.
2	Төлгөн хуц	30.0	42.0	1.8	9	14	85	46-50	
3	Эм хонь	37.0	50.0	1.7	8	13	84	44-48	
4	Охин төлөг	28.0	40.0	1.5	9	10	87	46-50	
2. Говь-Алтай үүлдрийн хонь									
1	Нас гүйцсэн хуц	53.0	68.0	2.1	12	15	85	46-48	Нийтлэг босго үзүүлэлтүүдийг хангахын зэрэгцээ Говь-Алтай үүлдрийн хонь нь харьцангуй бие томтой, ноосны гарц, чанар сайтай, бүдүүвтэр ноостой, мах-ноосон ашиг шим тэнцүү хосолсон, халзан, хар нүдэн өөхөн сүүлтэй, эрүүл чийрэг хонь байна.
2	Төлгөн хуц	32.0	48.0	1.8	10	13	88	46-50	
3	Эм хонь	38.0	53.0	1.6	9	10	85	44-48	
4	Охин төлөг	30.0	42.0	1.4	8	12	88	46-50	
3. Сартуул үүлдрийн хонь									
1	Нас гүйцсэн хуц	50.0	65.0	2.0	10	16	79	44-46	Нийтлэг босго үзүүлэлтүүдийг хангахын зэрэгцээ Сартуул үүлдрийн хонь нь мах-ноосон ашиг шимийн хослолын хувьд махны шинж арай илүү, бүдүүвтэр ноостой, халзан хар толгойтой, өөхөн сүүлтэй, эрүүл чийрэг хонь байна.
2	Төлгөн хуц	32.0	45.0	1.4	9	14	82	46-50	
3	Эм хонь	38.0	50.0	1.5	8	12	78	44-48	
4	Охин төлөг	29.0	40.0	1.2	7	13	80	44-50	
4. Дархад үүлдрийн хонь									
1	Нас гүйцсэн хуц	48.0	65.0	1.8	11	15	84	46-48	Нийтлэг босго үзүүлэлтүүдийг хангахын зэрэгцээ Дархад үүлдрийн хонь нь мах, ноос тэнцүү хосолсон ихэвчлэн эвэргүй, богиновтор зузаан дугуй өөхөн сүүлтэй, халзан, хар толгойтой, эрүүл чийрэг хонь байна.
2	Төлгөн хуц	32.0	45.0	1.3	9	14	86	46-50	
3	Эм хонь	38.0	50.0	1.5	8	13	85	44-48	
4	Охин төлөг	28.0	42.0	1.2	7	10	87	40-50	
5. Тамир үүлдрийн хэсгийн хонь									
1	Нас гүйцсэн хуц	49.0	64.0	2.0	9	16	78	44-46	Нийтлэг босго үзүүлэлтүүдийг хангахын зэрэгцээ Тамир үүлдрийн хэсгийн хонь нь бүдүүвтэр ноос-махан ашиг шимийн зохистой хослолыг шингээсэн, махны шинж арай илүү тодорсон, өөхөн сүүлтэй, хар
2	Төлгөн хуц	35.0	52.0	1.2	8	14	82	46-50	
3	Эм хонь	39.0	53.0	1.6	8	13	79	40-46	
4	Охин төлөг	29.0	43.0	1.2	7	12	83	46-50	

									нүдэн, хар толгойтой, эрүүл чийрэг хонь байна.
6. Сутай омгийн хонь									
1	Нас гүйцсэн хуц	52.0	65.0	1.8	9	15	80	44-48	Нийтлэг босго үзүүлэлтүүдийг хангахын зэрэгцээ Сутай омгийн хонь нь бүдүүвтэр ноостой, махлаг шинж арай илүү тодорсон, халзан, хар толгойтой, хөл, шилбэндээ цоохор толботой, өөхөн сүүлтэй, эрүүл чийрэг хонь байна.
2	Төлгөн хуц	33.0	45.0	1.5	8	13	82	46-50	
3	Эм хонь	39.0	53.0	1.6	8	12	80	44-48	
4	Охин төлөг	30.0	42.0	1.4	7	11	84	46-50	

Хавсралт 1 4

Мах-өөх-бүдүүвтэр ноосны чиглэлийн цөм сүргийн хонинд хувьсын ангилалт хийхэд хөтлөх бүртгэлийн маягтын загвар.

..... аймгийн сумын багийн малчин
..... овогтой-ын үүлдрийн цөм сүргийн
хонинд хувьсын ангилалт хийсэн дэлгэрэнгүй бүртгэл

..... оны сарын ... өдөр

№	Хувьсын дугаар	Хонины			Хаврын амьдын жин кг	Ноосны				Тайлбар
		Хүйс	Нас	Зүс		Урт см		Чанар	Ноолуурын эзлэх хувь	
						Ноолуурын	Сор үсний			
1										
2										
3										
.										
.										
.										
.										
.										
.										
n										

Ангилалт хийсэн:

Ажлын хэсгийн ахлагч /
 Гишүүд..... /
 /
 /
 /

**Гурав. “Мах – өөх – бүдүүн, бүдүүвтэр ноос”- ны чиглэлийн
ууцан сүүлт хонь ангилах заавар**

“Мах – өөх – бүдүүн, бүдүүвтэр ноос”- ны чиглэлд дараах үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсгийн хонийг хамруулна:

- 1) Керей үүлдрийн хонь
- 2) Алтанбулаг үржлийн хэсгийн хонь
- 3) Торгууд үүлдрийн хэсгийн хонь

Ангилалт явуулах хугацаа: Торгууд үүлдрийн хэсгийн хонинд ангилалтыг жил бүрийн 5 дугаар сарын эхний хагаст ноосон ашиг шимийн, 10 дугаар сарын эхний хагаст багтаан мах-өөхний чиглэлийн үндсэн үзүүлэлтүүдийг тус тус шинжиж жилд 2 удаа үзлэг, ангилалт явуулна. Керей үүлдрийн болон Алтанбулаг үржлийн хэсгийн хонинд жил бүрийн 10 дугаар сарын эхний хагаст багтаан мах-өөхний чиглэлийн үндсэн үзүүлэлтүүдийг шинжиж ангилалт явуулна.

Ангилалт хийх зарчим: Ашиг шимийн энэ чиглэлийн хонины зүс, шүд, хөл мөчний болон үржлийн эрхтэн, дэлэн хөхний хэлбэр хэмжээ, галбир, биеийн ерөнхий өсөлт хөгжилт, эрүүл мэнд, тэсвэрт чанарын зэрэг үзүүлэлтүүд нь “Мах – өөх - бүдүүн ноос”-ны чиглэлийн өөхөн сүүлт хонь ангилах заавартай ижил бөгөөд амьдын жин, махлаг шинж, биеийн галбир, ууцан сүүлний байдал зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан аль сүрэгт хамрагдахыг тодорхойлох зарчим баримтална.

3.1. “Мах – өөх – бүдүүн ноост” ууцан сүүлт хонь ангилах:

Цөм сүрэгт хамрагдах хонь:

Махны хонины хэв шинж сайн тодорсон, эрүүл чийрэг бие цогцостой, биеийн хэсгүүд жигд хөгжсөн, салаалаагүй буюу бага зэрэг ацалж салаалсан, өргөгдсөн том ууцан сүүлтэй, мухар эсвэл жижиг эвэртэй, намрын амьдын жингээр тухайн нас, хүйсний хонины босго үзүүлэлтийг хангасан, бор, улаан зүстэй байна.

Үржлийн сүрэгт хамрагдах хонь:

Цөм сүргийн хонины амьдын жингийн босго үзүүлэлтээс бусад үзүүлэлтийг хангасан хонийг хамруулна.

Хэрэгцээний сүрэгт хамрагдах хонь:

Өсөлт хөгжилт, махлаг шинж муутай, галбирын согогтой, нас хөгширсөн, огтор эсвэл урт отготой, унжгардуу өөхөн сүүлтэй, өвчин эмгэгтэй, тухайн нас, хүйсний цөм сүргийн хонины амьдын жингийн босго үзүүлэлтээс 20%-иар доогуур, янз бүрийн зүстэй, жижиг давжаа биетэй;

3.2. “Мах – өөх – бүдүүвтэр ноост” ууцан сүүлт хонь ангилах:

Нийтлэг үзүүлэлтүүд нь “Мах–өөх-бүдүүн ноос”-ны чиглэлийн ууцан сүүлт хонь ангилах заавартай ижил бөгөөд ноосорхог шинжүүдийн гадаад илэрхийлэл болох ноосон дахь үсний төрлийн харьцаа, ноолуур, сор үсний урт, голч, жигдлэг зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан аль сүрэгт хамрагдахыг тодорхойлно.

Цөм сүрэгт хамрагдах хонь:

- Махны хонины хэв шинж сайн тодорсон, эрүүл чийрэг бие цогцостой, биеийн хэсгүүд жигд хөгжсөн, салаалаагүй буюу бага зэрэг ацалж салаалсан, өргөгдсөн том ууцан сүүлтэй, мухар эсвэл жижиг эвэртэй, намрын амьдын жингээр тухайн нас, хүйсний босго үзүүлэлтийг хангасан, улаан бор, хүрэн зүстэй, бүдүүвтэр ноостой байна.
- Хонины гэдэс хээлүүрийн ноосжилт сайтай, урд, хойд хөлний ноосжилт өвдөг, борвио хүртэл үргэлжилсэн, ямаан үсгүй, туг хэлбэрийн бүдүүвтэр ноостой;
- Ноосны чанар /Ноолуур, сор үсний урт, голч, ноолуурын эзлэх хувь/ нь хавсралтад заасан тухайн нас, хүйсний хонины босго үзүүлэлтүүдийг хангасан байх;

Үржлийн сүрэгт хамрагдах хонь:

Цөм сүргийн хонины амьдын жин, ноосон ашиг шимийн босго үзүүлэлтийн аль нэгийг хангаагүй боловч бусад үзүүлэлтийг хангасан хонийг хамруулна.

Хэрэгцээний сүрэгт хамрагдах хонь:

Өсөлт хөгжилт, махлаг болон ноосорхог шинж муутай, галбирын согогтой, өвчин эмгэгтэй, тухайн нас, хүйсний цөм сүргийн хонины амьдын жингийн босго үзүүлэлтээс 20%-иар доогуур, жижиг давжаа биетэй, ноосон дахь ноолуурын эзлэх хувийн жин 60%-иас доош үзүүлэлттэй;

**“Мах – өөх – бүдүүн, бүдүүвтэр ноос”-ны чиглэлийн ууцан сүүлт
хонины цөм сүргийн босго үзүүлэлтүүд**

№	Нас, хүйсний ялгаа	Амьдын жин. кг		Ноосны		Товч тайлбар
		Хаврын	Намрын	Гарц кг	Чанар	
1. Керей үүлдрийн хонь						
1	Нас гүйцсэн хуц	50.0	70.0	1.8	40-44	Галбирын согоггүй, чийрэг бие цогцостой, мах-өөхний шинж сайн тодорсон, том биетэй, өргөгдөж ацалсан том ууцан сүүлтэй, бага зэрэг ямаан үс бүхий өтгөн бүдүүн ноостой, улаан бор, хүрэн зүстэй, ихэвчлэн эвэртэй, дэлдэн чихтэй, эрүүл хонь байна.
2	Төлгөн хуц	32.0	48.0	1.6	44-46	
3	Эм хонь	38.0	56.0	1.3	40-44	
4	Охин төлөг	30.0	45.0	1.1	44-46	
2. Алтанбулаг үржлийн хэсгийн хонь						
1	Нас гүйцсэн хуц	58.0	76.0	1.4	40-44	Уртавтар, том биетэй, махлаг шинж сайн тодорсон, лагс чийрэг бие цогцостой, ууц нуруу хондлой шулуун, өргөн гүн цээжтэй, хөлийн тавилт зөв, салаалаагүй, отгогүй том ууцан сүүлтэй, улаан бор, хүрэн зүстэй, бүдүүн ноостой, эрүүл хонь байна.
2	Төлгөн хуц	36.0	60.0	1.2	44-46	
3	Эм хонь	43.0	58.0	1.3	40-44	
4	Охин төлөг	33.0	50.0	1.1	40-46	
3. Торгууд үүлдрийн хэсгийн хонь						
1	Нас гүйцсэн хуц	55.0	65.0	2.2	46-50	Биеэр том, галбирын согоггүй, чийрэг бие цогцостой, уртавтар чацтай, нилээд өргөгдсөн ууцан сүүлтэй, толгой, шилбэ нь бор боловч их бие нь цайвар, цагаан бор зүстэй, ноосны урт өтгөн хангалттай, ямаан үсгүй, ноосорхог байдал сайн хөгжсөн бүдүүвтэр ноостой эрүүл хонь байна.
2	Төлгөн хуц	38.0	55.0	1.6	48-50	
3	Эм хонь	42.0	50.0	2.0	44-48	
4	Охин төлөг	32.0	43.0	1.4	48-50	

**Мах-өөх-бүдүүн, бүдүүвтэр ноосны чиглэлийн ууцан сүүлт
хонины цөм сүрэгт хувьсын ангилалт хийхэд хөтлөх
бүртгэлийн маягтын загвар.**

..... аймгийн сумын багийн малчин
..... ОВОГТОЙЫН үүлдрийн цөм сүргийн
хонинд хувьсын ангилалт хийсэн дэлгэрэнгүй бүртгэл

..... оны сарын ... өдөр.

№	Хувьсын дугаар	Хонины			Намрын мьдын жин кг	Сүүлний Хэмжээ /урт өргөн/	Тайлбар
		Хүйс	Нас	Зүс			
1							
2							
3							
.							
.							
.							
.							
n							

Ангилалт хийсэн:

Ажлын хэсгийн ахлагч /
 Гишүүд..... /
 /
 /
 /

Дөрөв. Нарийн, нарийвтар ноост хонь ангилах заавар

Нарийн, нарийвтар ноосны чиглэлд дараах үүлдэр, үүлдрийн хэсэг, үржлийн хэсгийн хонийг хамруулна:

- 1) Нарийн ноост Хангай үүлдрийн хонь
- 2) Нарийвтар ноост Орхон үүлдрийн хонь
- 3) Нарийвтар ноост Тал нутгийн цагаан үүлдрийн хонь
- 4) Нарийвтар ноост Ерөө үүлдрийн хэсгийн хонь
- 5) Нарийвтар ноост Жаргалант үржлийн хэсгийн хонь

Ангилалт явуулах хугацаа: Ашиг шимийн энэ чиглэлд хамрагдах дээрх үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсгийн хонийг үржүүлж байгаа иргэд, аж ахуйн нэгжийн хонинд ангилалтыг жил бүрийн 5 дугаар сарын хоёрдугаар хагаст багтаан ноосон ашиг шимийн болон галбир, бие цогцсын үндсэн үзүүлэлтүүдийг хослуулан шинжиж ангилна.

Жил бүр цөм сүрэгт хамрагдсан хонинд хяналтын хяргалт хийж 10 дугаар сард амьдын жинг тодорхойлж, үржлийн гэрчилгээнд тус тус баяжилт хийнэ.

Ангилалт хийх зарчим: Нийтлэг үзүүлэлтүүд нь “Мах – өөх - бүдүүвтэр ноос”-ны чиглэлийн хонь ангилах заавартай ижил бөгөөд ноосны урт, өтгөн, чанар, жигдлэг, атирааны тоо зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан аль сүрэгт хамрагдахыг тодорхойлно.

Ноосны нарийнийг далны араар ангилалтын гурвалжин, гуянд тодорхойлж дараах чанарын аль болохыг тоогоор тэмдэглэнэ. Харин үржлийн хуцны ноосны нарийнийг дал нуруу, гуя гэдсэнд тодорхойлно.

Нарийний чанар	Нарийн микрон	1 см-т байх атирааны тоо
80	14,5- 18,6	9
70	18,1- 20,5	8
64	20,6-23,0	7
60	23,1-25,0	6
58	25,1-27,0	5
56	27,1-29,0	4-3
50	29,1-31,0	4-3
48	31,1-34,0	3-1
46	34,1-37,0	3

Цөм сүрэгт хамрагдах хонь:

- Ноосны хэв шинж сайн тодорсон, эрүүл чийрэг бие цогцстой, галбирын согоггүй, биеийн хэсгүүд жигд хөгжсөн, хавар, намрын амьдын жин, ноосны

гарц, чанарын үзүүлэлтээр тухайн нас, хүйсний цөм сүргийн хонины босго үзүүлэлтийг хангасан, хундан зүстэй, багц хэлбэрийн нарийн, нарийвтар ноостой байх;

- Хонины хоёр нүдний дунд болон шанаа, чихний уг орчмын толгойн ноосжилт, өвдөг, борвио хүрсэн хөлний болон гэдэс хээлүүрийн ноосжилт сайтай, их биеийн ноосны нарийн 2 –оос илүүгүй чанарын зөрүүтэй байх;

Үржлийн сүрэгт хамрагдах хонь:

Цөм сүргийн хонины амьдын жин, ноосны гарц, чанарын босго үзүүлэлтийн аль нэгийг хангаагүй боловч бусад үзүүлэлтийг хангасан хонийг хамруулна.

Хэрэгцээний сүрэгт хамрагдах хонь:

Галбирын элдэв согогтой, өсөлт хөгжилт хангалтгүй, өвчин эмгэгтэй, давжаа жижиг биетэй, эмзэг /чих, нүд, хамрын үзүүр улайсан, гэдэсний ноосжилтгүй/ үндсэндээ үржил сүргийн хонины шаардлагыг хангаагүй харлаг, борлог зүстэй хонийг хамруулна.

**“Нарийн, нарийвтар ноос-мах-өөх”-ны чиглэлийн шодон сүүлт
хонины цөм сүргийн босго үзүүлэлтүүд**

№	Нас, хүйсний ялгаа	Амьдын жин. кг		Ноосны					Товч тайлбар
		Хаврын	Намрын	Гарц кг	Урт см	Жигдлэг	Атирааны тоо	Чанар	
1. Хангай үүлдрийн хонь									
1	Нас гүйцсэн хуц	65	80	5.0	7.0	60/64	5-7	60-64	Биеэр том, чийрэг бие бялдартай, ясжилт сайтай, бөх бат арьстай, 60-64 дүгээр чанарын багц хэлбэрийн жигд нарийн ноостой, зунгаг нь цагаан цайвар, цайвар шаргал өнгөтэй, толгой хөлний ноосжилт сайтай, гэдэс хээлүүр ноосорхог эрүүл чийрэг хонь байна.
2	Төлгөн хуц	36	45	3.5	6.5	60/70	6-8	60-70	
3	Эм хонь	42	55	3.3	6.5	60/64	5-7	60-64	
4	Охин төлөг	30	38	3.0	7.0	60/70	6-8	60-70	
2. Орхон үүлдрийн хонь									
1	Нас гүйцсэн хуц	60	70	4.5	8.0	56/58	3-5	56-58	Галбирын согоггүй, чийрэг бие цогцостой, ноосорхог хэв шинж сайн тодорсон, жигд нарийвтар багц хэлбэрийн ноостой, ноосны уртын 1/4-1/5 хувьд хүртэл зунгагтай, хундан зүстэй эрүүл хонь байна.
2	Төлгөн хуц	35	50	3.0	8.5	56/58	4-5	56-58	
3	Эм хонь	40	55	3.0	8.0	50/58	3-5	50-58	
4	Охин төлөг	30	48	2.5	8.0	56/58	3-5	56-58	
3. Тал нутгийн цагаан үүлдрийн хонь									
1	Нас гүйцсэн хуц	58	70	4.5	8.0	56/58	3-4	56-58	Чийрэг бие бялдартай, арьс үрчлээсгүй, багц хэлбэрийн жигд нарийвтар ноостой, ноосорхог байдал тод илэрсэн, цайвар шаргал өнгийн зунгагтай, зүс хундан боловч толгой, чих, хөлөнд өөр өнгийн үс, толботой байж болно.
2	Төлгөн хуц	38	45	3.2	8.0	56/58	3-4	56-58	
3	Эм хонь	41	50	2.8	7.0	50/58	3-4	50-58	
4	Охин төлөг	32	40	2.5	7.5	56/58	3-4	56-58	
4. Ерөө үүлдрийн хэсгийн хонь									
1	Нас гүйцсэн хуц	65	70	4.5	11.0	56/58	3-5	56-58	Чийрэг бие бялдартай, махлаг шинж сайн илэрсэн, харьцангуй урт, гялалзсан өнгөлөг, багц хэлбэрийн нарийвтар ноостой, атираа тод өнгөлөг, ноос-махан ашиг шим тэнцүүхэн хосолсон, хундан зүстэй нүд, чих, хөлөнд шар бор өнгийн толботой эрүүл хонь байна.
2	Төлгөн хуц	38	45	3.2	12.0	56/58	3-5	56-58	
3	Эм хонь	44	52	2.9	9.0	50/58	3-5	50-58	
4	Охин төлөг	30	40	2.8	10.0	56/58	3-5	56-58	
5. Жаргалант үржлийн хэсгийн хонь									
1	Нас гүйцсэн хуц	55	62	3,5	8,0	56/58	3-5	56-58	Чийрэг бие бялдартай, галбирын согоггүй, мах, өөх, ноосны ашиг шимийн шинж тод илэрсэн, богино
2	Төлгөн хуц	35	45	2,8	7,5	58/60	5-6	58-60	

3	Эм хонь	41	50	2,5	7,0	50/58	2-5	50-58	зузаан өөхөн сүүлтэй бөгөөд 56-60 дугаар чанарын багц хэлбэрийн нарийвтар ноостой, хундан цагаан зүсний хонь байна.
4	Охин төлөг	32	38	2,2	7,5	56/58	5-6	56-58	

Хавсралт № 8

**Нарийн нарийвтар ноос, мах өөхний чиглэлийн хонины
цөм сүрэгт хувьсын ангилалт хийхэд хөтлөх
бүртгэлийн маягтын загвар.**

..... аймгийн сумын багийн малчин
..... ОВОГТОЙЫН үүлдрийн цөм сүргийн
хонинд хувьсын ангилалт хийсэн дэлгэрэнгүй бүртгэл

..... оны сарын ... өдөр.

№	Хувьсын дугаар	Хонины			Хаврын мьдын жин кг	Ноосны					Тайлбар
		Хүйс	Нас	Зүс		Гарц кг	Урт см	Жигдлэг	Атирааны тоо	Чанар	
1											
2											
3											
.											
.											
.											
.											
n											

Ангилалт хийсэн:

Ажлын хэсгийн ахлагч /
 Гишүүд..... /
 /
 /
 /

Тав. Хурганы арьсны чиглэлийн бүдүүн ноост, урт өөхөн сүүлт хонь ангилах заавар

Хурганы арьсны чиглэлийн хонины удамзүйн нөөцийг хамгаалан сайжруулж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тал дугуй, хавирган, хавтгай, сахлаг гэсэн хэвшилтэй, долгион маягийн буржгартай, маш гоёмсог зураглалтай хар, саарал, сорлог, ягаан, цагаан өнгийн сайн чанарын арьс үйлдвэрлэхэд чиглэгдсэн байдаг.

Сүмбэр үүлдрийн хонин сүргийн дотроос тохиромжтой хэвшлийн шаардлага хангасан цөм сүрэгт тэнцэх хонийг шилэн сонгож, өсвөр хээлтүүлэгч бойжуулж зохистой ашиглахын зэрэгцээ үржлийн сүрэгт тэнцэхгүй хонийг сүргээс ширвэж, үржил сүргийн бие бялдар, ашиг шимийн гарц, чанарыг хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах зорилгоор ангилалт явуулна.

Ангилалт явуулах хугацаа: Хурганы арьсны чиглэлийн хонинд шилэлт, ангилалтыг явуулахдаа дор дурьдсан дарааллыг баримтлана:

- Хургыг эхээс төрсний дараа 1-5 хоногийн настайд нь ангилж, анхны шилэлт сонголтыг явуулах;
- Үржилд сонгосон хуцан хурганд 10-15 хоногийн настайд нь өсөлт торнилт, үсний буржгарын хадгалалт, туяарал, торгомсог байдал, зүсний өөрчлөлт зэргийг харгалзан дахин үнэлэлт өгөх;
- Чиглэлтэй өсгөн бойжуулсан төлгөн хуц, охин төлгийг 1.5 настай болсон үед нь өсөлт хөгжилт, галбир, бие бялдарын болон амьдын жин, ноосон ашиг шимийн цөм сүргийн босго үзүүлэлтийг үндэслэн жил бүрийн 05 дугаар сарын сүүлийн хагаст багтаан ангилалт хийж, жишигт тэнцсэн хэсгээр нь сүрэг сэлбэнэ.

Ангилалт хийх зарчим: Хургыг ангилахдаа доорх зарчим баримтална.

- Ангилалтад бүх хургыг бүрэн хамруулж, хувьсын ангилалтын журнал хөтлөх ба арьсны чиглэлийн хурга ангилах схемийг баримтлана.
- Цөм сүргээс хуц тавих болон сүрэг сэлбэх охин хургыг 1-5 хоногтойд сонгож 10-15 хоногтойд нь өсөлт торнилт, үсний будагшрал, торгомсог чанар, туяарал, буржгарын хадгалалт, 1.5 настайд нь галбир, зүс, амьдын жин, өсөлт хөгжилт, бие бялдар ноосорхог байдал зэргийг харгалзан эцсийн үнэлгээ өгнө.
- Хонь төллөж эхлэхээс дуусах хүртэл хурга ангилалтыг үргэлжлүүлэх;
- Үржилд сонгож үлдээсэн хурганд суурь, өрх бүрээр анги чанарын бүртгэл хөтөлнө; /маягт №351-361/

- Ангилалт эхлэхийн өмнө мал төллөх явцад малчин ангилагдаагүй хурга бүрт эхийн номертэй адил дугаартай хулдаасан номер зүүж төрсөн сар, өдрийг тэмдэглэсэн байх ба ангилагч малзүйч бүх хургыг ангилан арьсанд тэнцсэн хургыг нядалгаанд авч үржилд үлдэх хургыг анги, хэвшил тавьж хувьсын ангилалтын журналыг хөтлөнө. Үржилд үлдээж байгаа хуцан хурга, сүрэг сэлбэх охин хурганд бүртгэлийн код бүхий ээмгээр ээмэглэж бүртгэл мэдээллийн цахим санд бүртгэнэ.

Эхээс төрсний дараах 1-5 хоногийн настай хурганд ангилалт хийх:

Хурганы арьсны чиглэлийн 1-5 хоногийн настай хурганы арьс нь өвөрмөгц хээтэй, маш гоёмсог буржгартай, хөнгөн нимгэн хөрстэй, үс нь маш торгомсог, уян хатан, чанар сайтай, олон янзын өнгөтэй байдгаараа онцлог юм.

Энэ үед нь бүх хурганд ангилалт хийж, эр хурганаас хуц тавихыг, охин хурганаас сүрэг сэлбэхийг тус тус сонгож авахын зэрэгцээ нийт эр хурганы 30-аас доошгүй хувийг ялган нядалж, арьс бэлтгэнэ. Үүнээс хугацаа хэтэрвэл хурганы үсний буржгар алдагдаж, хэрэглэгчдийн шаардлагыг хангаж чадахгүйд хүрэх эрсдэлтэй. Хурганд ангилалт хийж, үржлийн хонийг сонгохдоо:

- Хурганы хүйс (эр, охин);
- Хурганы зүс (хар, саарал, сорлог, хүрэн, ягаан) хар хурганд өнгө зүснээс гадна үсний будагшралын байдал, саарал, ягаан хурганд өнгөшрөлийн жигд тархсан байдал, сорлог ягаан хурганд соржилтын байдлыг харгалзана.
- Арьсны хэвшил (тал дугариг, хавтгай, хавирган, сахлаг);
- Буржгарын хэмжээ (жижиг- 4мм хүртэл, дунд – 4-7мм, том-8мм-ээс дээш буюу хараас бусад өнгийн хурганд 2 мм-ээр илүү байх);
- Буржгарын хэлбэр (тал дугираг долгио, хавтгай ба хавирган долгио, буурцаг, дэл, цагираг, эргүүлэг шош шингэн үс);
- Буржгарын нягт (нягт, сийрэг, сийрэгдүү);
- Долгионы урт (богино -20 мм хүртэл, дунд долгио – 20-40 мм, урт долгио – 40 мм-ээс дээш);
- Үсний өтгөн;
- Торгомсог чанар;
- Туяарал;
- Арьсны зураглал тодорсон байдал;
- Толгой, хөл, хээлүүр сүүлэнд буржгар үсний тархсан байдал, түүний зураглал;
- Арьсны нягт, зузаан, нөөц;

- Хурганы өсөлт хөгжилт, бие бялдар, амьдын жин зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэнэ.

Цөм сүрэгт хамрагдах хонь:

- Бүдүүн ноостой, нугарсан урт өөхөн сүүлтэй, толгойн хэсэг нь богино ширүүн гялгар туяатай үсээр хучигдсан, уртавтар унжуу чихтэй;
- Галбирын ямар нэг согоггүй, чийрэг бие цогцостой, хэвийн өсөлт хөгжилттэй;
- Арьс нь нягт, дунд зэргийн зузаан хөрстэй, ердийн гялгар туяатай, торгомсог чанар сайтай, зунгаг ихтэй;
- Дунд зэргийн бүдүүнтэй сор үснээс голлон тогтсон нягт долгион хэлбэрийн буржгар жигд тархсан, тод зураглалтай;
- Тал дугираг (жакет), ребрист (хавирган), полоский (хавтгай), кавказ (сахлаг) хэвшилд хамаарах буржгар нь нягт, үс нь өтгөн торгомсог, атирааны зураглал тод, хөл, толгой, хээлүүр, сүүлэндээ буржгар атираатай ердийн өсөлт хөгжилттэй чийрэг бие цогцостой **хар зүсмийн**;
- Тал дугираг (жакет), ребрист (хавирган), полоский (хавтгай), кавказ (сахлаг) хамаарах цэнхэр, мөнгөлөг, буурал туяаралтай, нэгэн жигд зүстэй буржгар нь нягт, үс нь өтгөн, торгомсог, ердийн гялгар туяатай, хээний зураглал тод, хээлүүрийн үсжилт сайтай, хэвийн өсөлт чийрэг бие цогцостой **саарал зүсмийн**;
- Тал дугираг (жакет), ребрист (хавирган), полоский (хавтгай), кавказ (сахлаг) хэвшилд хамаарах үсний уг нь хар буюу хар хүрэн, дунд хэсэг нь цайвар хүрэн, үзүүр нь цагаан буюу ягаан туяатай цайвар үстэй маш гоёмсог өнгөтэй **сорлог** (Нэг үсний уртад 2-оос дээш өнгөтэй үстэй хургыг сорлог буюу сур) **зүсмийн**;
- Эр хургаар хуц тавих, охин хургаар цөм сүрэг сэлбэхээр тус тус сонгож, хувьсын дугаартай болгож, цөм сүргийн бүртгэлд хамруулна.

Үржлийн сүрэгт хамрагдах хонь:

Цөм сүрэг сэлбэх охин хурганд тавигдаж байгаа зүс, арьсны хэвшил, буржгарын хэмжээ, хэлбэр, хэвшил, нягт, долгионы урт, үсний өтгөн, арьсны зураглал тодорсон байдал, толгой, хөл, хээлүүр сүүлэнд буржгар үсний тархсан байдал, түүний зураглал, хурганы өсөлт хөгжилт, бие бялдар, амьдын жин зэрэг үзүүлэлтийн аль нэгийг хангаагүй боловч бусад үзүүлэлтийг хангасан охин хургыг хамруулна.

Хэрэгцээний сүрэгт хамрагдах хонь:

Үржлийн сүргийн шаардлага хангаагүй хээлтэгч болон хуц тавих шаардлага хангаагүй эр хургыг хэрэгцээний сүрэгт хамруулна.

15 хоногийн настай хурган хуц нь:

Анхны сонголтоор шилэгдсэн 15 хоногийн настай хурган хуц бүрийг дахин үнэлэхдээ өсөлт хөгжилт, тарга хүч сайтай, буржгараа сайн хадгалсан, ердийн туяатай, торгомсог үстэй, сүүл хээлүүртээ хуурай ширүүн үсгүй, анхныхаа зүсийг сайтар хадгалж байгаа зэрэг босго үзүүлэлтүүдийг харгалзан үзлэг, ангилалтыг явуулна.

1.5 настай (18 сарын) төлгөн хуц, охин төлөг нь:

Ашиг шимийн энэ чиглэлийн хонийг шүд, хөл мөчний болон үржлийн эрхтэн, дэлэн хөхний хэлбэр хэмжээ, галбир, биеийн ерөнхий өсөлт хөгжилт, эрүүл мэнд, тэсвэрт чанарын зэрэг үзүүлэлтүүд нь “Мах – өөх - бүдүүн ноос”-ны чиглэлийн өөхөн сүүлт хонь ангилах заавартай ижил бөгөөд зүс, сүүлний онцлог үзүүлэлтүүдийг харгалзан аль сүрэгт хамрагдахыг тодорхойлох зарчим баримтална.

Хавсралт № 9

“Хурганы арьс - мах - ноос”-ны чиглэлийн “Сүмбэр” үүлдрийн урт өөхөн сүүлт хонины цөм сүргийн босго үзүүлэлтүүд

№	Хонины нас, хүйс	Амьдын жин / кг /		Ноосны гарц / гр /
		Хавар /V сард /	Намар /X сард /	
1	Бүдүүн хуц	54.0	68.0	2500
2	Төлгөн хуц	35.0	50.0	1600
3	Эм хонь	38.0	54.0	1800
4	Охин төлөг	30.0	45.0	1500

ЯМАА АНГИЛАХ ЗААВАР

Ноолуурын ямааны ангилалт: Манай оронд үржүүлж байгаа ямаан сүрэгт ашиг шимийн дараах чиглэлийн дагуу ангилалтыг жил бүр 3-4 дүгээр сард багтаан явуулж цөм сүрэгт тэнцсэн нас гүйцсэн ухна, борлон ухна, охин борлонгоос 3-5гр ноолуурын дээж авч лабораторид голчийг, хавар ангилалтын дараа цөм сүрэгт хамрагдсан ямаа бүрийн ноолуурын гарцыг самналтаар, 10 дугаар сард амьдын жинг тус тус тодорхойлж, үржлийн гэрчилгээнд баяжилт хийнэ. Ноос, ноолуурын төрөл, хэвшлээс хамаарч ямааны ашиг шимийн чиглэлийг дараах гурван хэсэгт хуваана.

Үүнд:

Кашимер ноолууртай ямаа

- 1) Монгол үүлдрийн ямаа
- 2) Завхан бууралүүлдрийн ямаа
- 3) Баяндэлгэрийн улаанүүлдрийн ямаа
- 4) Залаа жинст-Эдрэнүүлдрийн ямаа
- 5) Алтайн улаан үүлдрийн ямаа
- 6) Эрчимийн хар омгийн ямаа
- 7) Өлгийн улаан омгийн ямаа
- 8) Бөмбөгөрийн улаан омгийн ямаа

Кашгор ноолууртай ямаа

- 1) Говь гурван сайхан үүлдрийн ямаа
- 2) Уулын бор үүлдрийн ямаа

Ноосны ямаа

- 1) Өнжүүл үржлийн хэсгийн ямаа

Ангилалт хийх зарчим: Ашиг шимийн чиглэлийн дагуу ямааг зүс, галбир, шүд, биеийн хэсгүүдийн хөгжил, харьцаа тухайлбал, хөл мөч, үржлийн эрхтэн, дэлэн хөхний хэлбэр, хэмжээ, эрүүл мэнд, тэсвэрт чанарын гадаад илэрхийлэл, амьдын жин, ноолуур агууламж, ноолуурын гарц, урт, нарийн бүдүүн (голч), жигдлэгийн үзүүлэлтийг харгалзан аль сүрэгт хамрагдахыг тодорхойлно.

Ангилалтад хамрагдах ямааны нас, хүйс: Жил бүр шинээр сүрэг сэлбэх борлон ухна, охин борлонд ангилалт, цөм сүргийн нас гүйцсэн ухна, эм ямаанд үзлэг, заазлалт хийнэ.

Цөм сүрэгт хамрагдах ямаа:

- Чийрэг бие цогцостой, галбирын согоггүй, ясжилт сайтай;
- Шүдний тоо тухайн ямааны насанд тохирсон бүрэн, бүтэн, зөв байршсан;
- Толгойн урт өргөний харьцаа зөв, дээд доод уруулын хөгжил ижилхэн, хар бараан өнгийн, хэвийн хэлбэр бүхий эвэртэй;
- Сэрвээ нуруу тэгш шулуун, өргөн, хондлой урт, өргөн, хоёр талын түнхний үе нэг түвшинд байрлалтай;
- Хөл шулуун, үе мөч, хөлийн гишгэлт хэвийн, зөв хөгжсөн, хар бараан өнгийн, бат бэх туруутай;
- Ухнын хоёр төмсөг нь ижил тэнцүүхэн хөгжилтэй, хуухнагийн уутанцарт зөв байрласан, хос төмсөг нь хэлбэр хэмжээгээр ижил, тэнцүү;
- Эм ямааны дэлэн нь аяга хэлбэртэй, суурь нь өргөсөж хэвлийд сайтар бэхлэгдсэн, хоёр хөхний хэлбэр, хэмжээ тэнцүүхэн зөв байрлалтай. Тулман буюу уутан хөхтэй байж болно;
- Тухайн үүлдэр, омгийн ямааны үндсэн зүстэй;
- Шанаа, чихний уг орчим, гэдэс хээлүүрийн ноолууржилт сайтай, урьд, хойд хөлний ноолуур өвдөг, тахир борвио хүрсэн өтгөн ноолууртай;
- Монгол үүлдэр ба түүнээс салбарласан үүлдэр, омгийн ямаа нь нуруу, ууц, хондлой,дал, гуяа дагасан урт хялгастай харин кашгор хэвшлийн ноолууртай ямааны их биеийн ноолуур хялгаснаас давж ургасан байж болно;
- Далны ар, гуяны ноолуурын голчийн (нарийн) зөрүү нэг мкм-ээс ихгүй;
- Тухайн үүлдэр, омгийн нас гүйцсэн ба өсвөр ухна, эм ямааны хавар, намрын амьдын жин, ноолуур агууламж, ноолуурын гарц, голч, уртаар заасан босго үзүүлэлтийг хангасан буюу тэдгээрээс дээш байвал зохино.

Үржлийн сүрэгт хамрагдах ямаа:

- Цөм сүргийн ямааны ашиг шимийн босго үзүүлэлтийн аль нэгийг хангаагүй;
- Тухайн үүлдэр, омгийн ямааны үндсэн зүснээс өөр зүсний их биед эзлэх хэмжээ 25 %-иас хэтрээгүй;
- Кашгор хэвшлийн ноолууртай ямааны ноолуурт завсрын үсний агууламж 10%-иас илүүгүй;
- Далны ар, гуяны хэсгийн ноолуурын голчийн зөрүү 1 мкм-ээс давсан, жигд биш ноолууртай;
- Хув чихтэй,мухар, эвэр хоорондын зай хэт бага, хэмжээ хэлбэр алдагдсан;

Хэрэгцээний сүрэгт хамрагдах ямаа:

Эмзэг бие цогцостой, галбирын согогтой, тухайнхнаас, хүйсний цөм сүргийн ямааны амьдын жингийн босго үзүүлэлтээс 20%-иар доогуур, жижиг давжаа биетэй, үндсэн зүснээс өөр зүстэй;

**Кашимер ноолууртай үүлдэр, омгийн цөм сүргийн ямааны ашиг шимийн гарц,
чанарын босго үзүүлэлт**

№	Нас, хүйс	Амьдын жин, кг		Ноолуурын				Өнгө	Үндсэн зүс
		хавар	намар	агуулам ж, %	гарц, гр	урт, мм	голч, мкм		
1. Монгол үүлдрийн ямаа									
1	Нас гүйцсэн ухна	44	56	40	320	45	≥15	цагаан, цайвар, бараан	Хар, улаан, хөх, цагаан
2	Борлон ухна	23	32	40	240	40	≥14		
3	Эм ямаа	32	41	35	260	45	≥15		
4	Охин борлон	21	31	35	240	45	≥14		
2. Баяндэлгэрийн улаан үүлдрийн ямаа									
1	Нас гүйцсэн ухна	48	60	45	470	45	≥16	цайвар, улаан цайвар	Улаан, үзмэн хүрэн,
2	Борлон ухна	25	38	40	370	45	≥15		
3	Эм ямаа	33	45	55	450	50	≥16		
4	Охин борлон	22	33	45	320	45	≥15		
3. Завхан буурал үүлдрийн ямаа									
1	Нас гүйцсэн ухна	49	61	45	400	50	≥16	цайвар, бараан	Хар, халтар,
2	Борлон ухна	26	39	45	350	50	≥15		
3	Эм ямаа	34	46	55	430	50	≥16		
4	Охин борлон	23	35	50	310	50	≥15		
4. Залаажинст -Эдрэн үүлдрийн ямаа									
1	Нас гүйцсэн ухна	47	59	45	400	50	≥16	цагаан	Бараан зовхитой ямар нэг толбогүй цагаан
2	Борлон ухна	23	34	45	320	50	≥15		
3	Эм ямаа	29	41	55	340	50	≥16		
4	Охин борлон	19	30	50	300	50	≥15		
5. Алтайн улаан үүлдрийн ямаа									
1	Нас гүйцсэн ухна	48	60	45	480	50	≥16	цайвар	Улаан, үзмэн хүрэн, мөнгөлөг сортой улаан
2	Борлон ухна	24	35	50	370	50	≥15		
3	Эм ямаа	30	46	60	400	50	≥16		
4	Охин борлон	21	29	55	300	50	≥15		
6. Өлгийн улаан омгийн ямаа									
1	Нас гүйцсэн ухна	49	57	45	370	45	≥16	цайвар	Улаан, үзмэн хүрэн,
2	Борлон ухна	26	36	45	270	45	≥15		
3	Эм ямаа	31	47	50	350	45	≥16		
4	Охин борлон	23	34	50	300	45	≥15		
7. Эрчимийн хар омгийн ямаа									
1	Нас гүйцсэн ухна	50	60	50	450	50	≥16	цайвар, бараан	Хар, мөнгөлөг сортой хар
2	Борлон ухна	24	35	50	360	45	≥15		
3	Эм ямаа	33	47	55	430	50	≥16		
4	Охин борлон	20	30	50	350	45	≥15		
8. Бөмбөгөрийн улаан омгийн ямаа									

1	Нас гүйцсэн ухна	46	55	45	360	50	≥16	цайвар	Улаан, үзмэн хүрэн, мөнгөлөг сортой улаан
2	Борлон ухна	25	35	45	350	45	≥15		
3	Эм ямаа	30	43	50	350	50	≥16		
4	Охин борлон	21	30	50	300	45	≥15		

Хавсралт №2

Кашгор ноолууртай үүлдрийн цөм сүргийн ямааны ашиг шимийн гарц, чанарын босго үзүүлэлт

№	Нас, хүйс	Амьдын жин, кг		Ноолуурын				Өнгө	Үндсэн зүс
		хавар	намар	агуулам ж, %	гарц, гр	голч, мкм	урт, мм		
1. Говь Гурван Сайхан үүлдрийн ямаа									
1	Нас гүйцсэн ухна	42	58	70	600	≥19	90	Бор саарал, цайвар шаргал	Хар
2	Борлон ухна	20	35	70	450	≥17	70		
3	Эм ямаа	28	39	75	550	≥18	80		
4	Охин борлон	20	30	70	400	≥17	70		
2. Уулын бор үүлдрийн ямаа									
1	Нас гүйцсэн ухна	43	59	75	700	≥19	90	Бор саарал, цайвар шаргал	Хар
2	Борлон ухна	20	35	75	500	≥17	70		
3	Эм ямаа	29	40	80	600	≥18	80		
4	Охин борлон	21	31	75	450	≥17	70		

Хавсралт №3

Ноосны чиглэлийн цөм сүргийн ямааны ашиг шимийн гарц, чанарын босго үзүүлэлт

№	Нас, хүйс	Амьдын жин, кг		Ноос, ноолуурын				Өнгө	Үндсэн зүс
		хавар	намар	ямаан үс %	гарц, гр	чанар	урт, мм		
1. Өнжүүл үржлийн хэсгийн ямаа									
1	Нас гүйцсэн ухна	50	60	0.5	1500	44 -50	180	Гялалзсан, торгомсог цагаан	Бараан зовхитой цагаан
2	Борлон ухна	25	35	0.5	1100	50 - 56	130		
3	Эм ямаа	35	45	0.5	700	46 - 50	180		
4	Охин борлон	22	30	0.5	600	50 -56	130		

**Ноосны чиглэлийн ямааны цөм сүрэгт
хувьсын ангилалт хийхэд хөтлөх
бүртгэлийн маягтын загвар.**

..... аймгийн сумын багийн малчин
..... ОВОГТОЙЫН үүлдрийн цөм сүргийн
ямаанд хувьсын ангилалт хийсэн дэлгэрэнгүй бүртгэл

..... оны сарын ... өдөр.

№	Хувьсын дугаар	Зүс	Хүйс	Нас	Амьдын жин, кг		Ноос, ноолуурын					
					хавар	намар	гарц, гр	ямаан үс, %	чанар	урт, мм	өнгө	

Төгсөв.